



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



From  
the People of Japan



Save the Children

## “ХҮҮХЭД БҮРИЙГ БОЛОВСРОЛД ТЭГШ ХАМРУУЛАХ ЗАРЧМЫГ ДЭМЖИХ НЬ-2” ТӨСӨЛ (2021-2024)

МЭДЭЭЛЛИЙН ХУУДАС №7

2023 оны 10-р сар



Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 2 дугаар дүнд сургуулийн багш Н.Цэвэлбадам ХХТ (Хүүхэд Хөгжлийн Төв)-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хотын зорилтот сургуулийн багш нарт танилцуулж байна.

Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 2-р сургуулийн ХХТ-ийн танхим, 2023.09.18

# “5 ДУГААР АНГИЙН СУРАГЧДЫГ БАГА АНГИАС ДУНД АНГИД ДЭВШИН СУРАЛЦАХАД БЭЛТГЭХ АРГА ЗҮЙ” СУРГАЛТ


2023 оны 8-р сар

Ховд, Өвөрхангай аймаг, нийслэлийн Чингэлтэй, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн нийт 16 сургуулийн 28 бага ангийн сургалтын менежер, багш нарыг хамруулан “5 дугаар ангийн сурагчдыг бага ангиас дунд ангид дэвшин суралцахад бэлтгэх арга зүй” модулийн сургагч багш нарын сургалтыг 2023 оны 08-р сарын 28-нд Монгол-Японы төвийн сургалтын танхимд зохион байгуулав.

Сургалтыг төслийн зөвлөх Нийслэлийн 63-р сургуулийн сургалтын менежер О. Мөнхцэцэг, МУБИС-ийн “Хүүхдийн Хөгжлийг Дэмжих Төв”-ийн эрхлэгч, доктор Д. Одгэрэл, БЕГ-ын мэргэжилтэн Ч. Нямдорж нар удирдан явууллаа.

Энэхүү модулийн арга зүйг 2022-2023 оны хичээлийн жилд туршин хэрэгжүүлж дахин сайжруулсан ба энэ хичээлийн жилд практикт суурилсан арга зүй, дадлага ажлуудыг сургалтын хөтөлбөрт түлхүү оруулж зохион байгуулсан.

Оролцогчид “Шилжилтийн хөтөлбөр”-ийг үнэлэх, сайжруулах, тогтвортой хэрэгжүүлэх, ТХХ-ийн хувийн мэдээллийг ашиглан шаардлагатай дэмжлэгийг шилжилтийн хөтөлбөрт тусган төлөвлөх арга зүйд суралцлаа.



Модуль 1 сургалтад хамрагдсан сургагч багш нар  
Монгол-Японы төв, Улаанбаатар хот,  
2023.08.28.



Доктор Д. Одгэрэл, “Хүүхдийн хувийн ялгаатай байдал” сэдэвт танилцуулаа хийж байна.  
Монгол-Японы төв, Улаанбаатар хот, 2023.08.28

# БАГШ НАРЫН ТУРШЛАГА СУДЛАХ АЯЛАЛ

2023 оны 9-р сар

Улаанбаатар хотын төслийн зорилтот 12 сургуулийн төлөөллөөс бүрдсэн 12 багш 2023 оны 09 сарын 18-19-ны өдрүүдэд туршлага судлах аяллыг Өвөрхангай аймгийн Арвайхээр хотын 2-р дунд сургууль, Уянга сумын 1-р сургуульд тус тус хийж, харилцан туршлагаа солилцлоо.

Энэхүү үйл ажиллагааны хүрээнд багш нар зорилтот сургуулийн төсөл хэрэгжүүлж байгаа явц, үр дүн, онцлог ажлуудын талаар мэдээлэл хуваалцах, тусгай бүлэг болон хүүхэд хөгжлийн танхимтай танилцах, ГСТ-өөр хичээллэж байгаа сурагчидтай бага болон дунд ангийн хичээлд ажиглалт, хэлэлцүүлэг хийх, үе тэнгийн сургагч багш нарын хэрэгжүүлж байгаа онцлог ажлуудтай танилцлаа. Мөн туршлага судлах аяллын үеэр сургуулиуд сургалтын хөтөлбөрийн тохируулга, багш нарын хичээл төлөвлөлт

болон сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх, шилжилтийн хөтөлбөрийн хэрэгжилт болон сурагчдын сурлагын хоцрогдол нөхөх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн арга туршлагаасаа харилцан хуваалцлаа.

Туршлага судлах уулзалтаар багш нар олон сайн туршлага, шинэ санаатай буцаж байгаа гэдгээ дүгнэлт хэлэлцүүлгийн үеэр дурдаж, зочилж очсон сургууль бүр төслийн хүрээнд хийгдэж байгаа ажлууд нь өөр өөрийн онцлог, брэнд ажил болж нутагшсан байгааг хэлж байлаа.



Арвайхээр сумын 2-р сургуулийн багш О.Одгэрэл технологийн хичээлийн хөтөлбөрийн тохиргоо хийснээ танилцуулж байна.  
Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 2-р сургууль, 2023.09.18.



УБ хотын багш нар Уянга сумын 1-р сургуулийн багш нарын хамт Өвөрхангай аймгийн Уянга сумын 1-р сургууль,  
2023.09.18.

# ЯПОН УЛСАД ЗОХИОН БАЙГУУЛСАН ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫН ТУРШЛАГА СУДЛАХ АЯЛАЛ

2023 оны 9-р сар



**БШУЯ, БЕГ, Ховд, Өвөрхангай аймгийн боловсролын газар болон төслийн зорилтот сургуулийн төлөөллөөс бүрдсэн 9 хүний баг төслийн менежерийн хамт 2023 оны 9 сарын 9-17-ны өдрүүдэд Япон улсад айлчиллаа.**

Тус аяллын зорилго нь Япон улсын боловсролын байгууллагуудад зочилж тус улсын тэгш хамруулах боловсролын үйл ажиллагаа, тогтолцооны талаар ойлголттой болох, Монгол улсад тэгш хамруулах боловсролын үйл ажиллагааг дэмжих тогтолцоог бий болгох, тогтвортой хөгжүүлэхэд өөрсдийн сурч мэдсэн зүйлсээ зориулахад оршино.

Аяллын оролцогчид Боловсролын Ерөнхий Газраас Хүүхдийг Ивээх Сан болон бусад байгууллагын дэмжлэгтэйгээр байгуулах тэгш хамруулах боловсролын мэргэжлийн дэмжлэгийн багийг манлайлан тэгш хамруулах боловсролын туршлагыг орон даяар түгээн дэлгэрүүлэх ажлыг удирдан чиглүүлэх үүрэгтэй юм.

Оролцогчид Токио болон түүний ойр орчмын бүс нутаг, Осака муж дахь ерөнхий боловсролын гурван сургууль (бага сургууль, дунд сургууль, ахлах сургууль), мужийн боловсролын хоёр зөвлөл, орон нутгийн нэг төрийн бус байгууллага болон бусад газруудын үйл

ажиллагаатай танилцсан. Юуны өмнө зочилсон сургуулиудын хүүхдийн хувийн хэрэгцээ, онцлогт нийцүүлэн чанартай сургах багш нарын арга барилтай танилцлаа. Тухайлбал, Канагава мужийн Ацуги-Ниши ахлах сургуулийн тэгш хамруулан сургах боловсролыг дэмжих асуудал хариуцсан мэргэжилтэн ноён Мунечика болон сургуулийн дэд захирал Сугияма нар багш нар багаар хичээл заах тогтолцоог нэвтрүүлж, хоёр багш нэг ангид хамтран хичээл, сургалтын үйл ажиллагаа явуулдаг туршлагаасаа хуваалцсан бол Канагава мужийн Чигасаки хотын Дайчи ахлах сургуулийн захирал хатагтай Харада суралцахуйн түгээмэл загварт түшиглэсэн сургалтыг бий болгоход сургууль нь хэрхэн анхаарч байгаа талаар бидэнд танилцуулсан.

Түүнчлэн, тэгш хамруулах боловсролын зорилтуудыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд сургуулиуд бусад байгууллагуудаас хэрхэн дэмжлэг авч, хамтран ажилладаг тухай ойлголттой болсон.

Жишээлбэл, Осака дахь боловсролын хоёр зөвлөл сургуулиудыг эрүүл мэндийн салбараас дэмжлэг авах боломжийг бий болгож өгдөг. Мөн Chiba MD Econet нэртэй орон нутгийн ТББ нь Чива мужийн Засаг даргын тамгын газартай хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд сургуулийн амьдралын талаар зөвлөгөө өгөх төслийг хэрэгжүүлсэн г.м.



Ацуги-Ниши ахлах сургуулийн захирал ноён Савада сургуулийнхаа тухай болон тэгш хамруулан сургах боловсролыг хэрхэн дэмжиж ажилладаг талаар танилцуулж байна. Канагава, Япон улс, 2023.09.11



Аяллын оролцогчид Чигасаки хотын Дайчи ахлах сургуулийн тусгай хэрэгцээт боловсролын ангийн үйл ажиллагаатай танилцаж, ажилалт хийж байна. Канагава, Япон улс, 2023.09.12

Оролцогчид зочилсон байгууллага бүрээс өөрсдийн сурсан мэдсэнээ тэмдэглэж, байгууллага тус бүрийг хариуцсан нэг оролцогч тайланг нэгтгэн илтгэл болгосон. Аяллын төгсгөлд тэд сурсан зүйлсээ бусадтайгаа хуваалцан, дүгнэх уулзалт хийв.



БШУЯ-ны Тэгш хамруулан сургах боловсролын хэлтсийн ахлах мэргэжилтэн, хатагтай Ч.Жаргал хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг дэмжин ажилладаг "No side" байгууллагад зочилсон туршлагаасаа танилцуулж байна. Хүүхдийг Ивээх Сангийн Токио дахь төв оффис, 2023.09.16.

# ТӨСЛИЙН ЗОРИЛТОТ СУРГУУЛИЙН ҮНДСЭН СУРГАЛТ

2023 оны 9-р сар

Төслийн хүрээнд сургагч багш бэлтгэх давтан сургалт 8 дугаар сард зохиогдсон ба бэлтгэгдсэн сургагч багш нар сургуулиуд дээрээ ерөнхий сургалтыг зохион байгуулж байна. Энэхүү ерөнхий сургалт нь төсөл хэрэгжиж буй 16 сургууль дээр 10 дугаар сард явагдах юм. Энэ нийтлэлд төсөл хэрэгжиж буй сургуулийн нэг болох Ховд аймгийн Ерөнхий боловсролын 7 дугаар сургуулийн ерөнхий сургалтыг онцолж байна.



Ховд аймгийн Ерөнхий боловсролын 7 дугаар сургууль 2023 оны 9 дүгээр сарын 22, 23-ний өдрүүдэд ерөнхий сургалтаа зохион байгууллаа. Ерөнхий сургалт нь дараах үндсэн 3 модулийн сургалт болон хүүхдийн оролцооны гарын авлагад зориулсан нэг нэмэлт сургалтаас бүрдэнэ.

Сургалт	Оролцогчдын тоо	Сургалт болсон өдөр
<b>Модуль 1:</b> “Тавдугаар ангийн сурагчдыг бага ангиас дунд ангид дэвшин суралцахад дэмжлэг үзүүлэх аргагүй”	4-5-р ангийн 8 багш	9 сарын 23, 2023
<b>Модуль 2:</b> “ЕБС-ийн дунд ангийн багш нарт зориулсан мэргэжил дээшлүүлэх сургалтын модуль”	Дунд ангийн 39 багш	9 сарын 23, 2023
<b>Модуль 3:</b> “Хүүхдийн сурах үйл явцад эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх арга зүй”	4-9-р ангийн анги удирдсан 26 багш	9 сарын 22, 2023
“Хамтдаа дэвшин суралцъя” гарын авлагын сургалт	18 сурагч	9 сарын 20, 2023

Ерөнхий сургалтын үеэр сургалтын өмнөх болон дараах тестийг сургалтад оролцогчдоос авдаг ба Модуль 2 сургалтын өмнөх болон дараах тестийн дундаж онооны зөрүү хамгийн их гарсан байна.



Сургалтын өмнөх тестийн дундаж оноо **7,7** байсан бол сургалтын дараах тестийн дундаж оноо **10,6** болж өсжээ.

Сургалтын өмнөх болон дараах тестийн дундаж онооны зөрүү 3,1 байгаа нь энэхүү сургалт нь дунд ангийн багш нарын тэгш хамруулан сургах хөтөлбөрийг

төлөвлөх, хэрэгжүүлэх талаарх ойлголтыг сайжруулсан гэдгийг харуулж байгаа юм.

Түүнчлэн, багш нар сургалтад идэвхтэй оролцоотой байв. Модуль 3 сургалтад оролцогч багш нарын идэвх хамгийн их байсан бөгөөд сургалтаар олж мэдсэн хүүхдийн судалгааны асуулга нь өсвөр насныхантай ажиллах, тэднийг таньж мэдэхэд чухал ач холбогдолтой байна гэдгийг багш нар онцолж байв.

Ховд аймгийн 7-р сургуулийн энэхүү ерөнхий сургалт амжилттай болж, цаашид ерөнхий сургалтаар олж авсан мэдлэгээ ашиглан сургууль дээрээ тэгш хамруулах боловсролын төслийг үр дүнтэй хэрэгжүүлэх болно гэж төслийн багийнхан дүгнэж байна.



Модуль 1 сургалт, бага боловсролын багш нар шилжилтийн төлөвлөгөөг хэрхэн боловсруулах талаар ярилцаж байна. Ховд аймгийн 7-р сургууль, багш нарын өрөө, 2023.09.23.



Модуль 2 сургалт, багш нар хамтран хөтөлбөрийн тохиргоо хийх дадлага ажил хийж байна. Ховд аймгийн 7-р сургууль, багш нарын өрөө, 2023.09.23.

# ОРОН НУТГИЙН ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫН БОДЛОГО БОЛОВСРУУЛАГЧ, СУРГУУЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТ

2023 оны 9-р сар



Орон нутгийн тэгш хамруулах боловсролын бодлого боловсруулагч, сургуулийн удирдах ажилтнуудад зориулсан сургалтыг Өвөрхангай аймгийн Богд зочид буудлын сургалтын танхимд 2023 оны 9-р сарын 25-нд зохион байгууллаа.

Сургалтад Өвөрхангай аймгийн Ерөнхий боловсролын дунд сургуулийн захирлууд, аймгийн ЗДТГ-ын холбогдох газар, хэлтсийн дарга, мэргэжилтнүүд, Уянга сумын ЗДТГ-ын төлөөллөөс бүрдсэн нийт 12 хүн оролцлоо.

Уг сургалтыг төслийн зөвлөх Р.Балжинням боловсруулсан гарын авлага дээрээ тулгуурлан удирдан явууллаа. Мөн төслийн зохицуулагч Ч.Пүрэв-Очир тэгш хамруулах боловсролын бодлого, эрх зүйн нөхцөл байдал, бодлогын нөлөөлөл, сурталчилгааны талаар оролцогчдод мэдээлэл өгч, танилцуулга хийлээ.



Сургалтад оролцогчид, Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын "Богд" зочид буудлын сургалтын танхим, 2023.09.25.

Сургалтад оролцогчид:



тэгш хамруулах боловсролын үзэл санаа,



манлайлагчийн ур чадвар,



байгууллагад тэгш боломжтой орчин бүрдүүлэх,



орон нутгийн боловсролын бодлого төлөвлөлт сэдвүүдийн хүрээнд шинэ мэдлэг мэдээлэлтэй танилцаж, төлөвлөлтийн дадлага ажлыг орон нутгийн жишээн дээр тулгуурлаж хийлээ.



Энэхүү сургалт практик ач холбогдолтой болсон тул тус тусын сургууль, байгууллага дээрээ зохион байгуулах болно гэж сургалтыг дүгнэх үеэр оролцогчид мэдэгдлээ.



Сургалтын зөвлөх Р.Балжинням тэгш хамруулах боловсролын манлайлагчийн ур чадварын талаар танилцуулж байна. Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын "Богд" зочид буудлын сургалтын танхим, 2023.09.25.

# “ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДҮҮДИЙГ БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ, ХҮЧИРХИЙЛЛЭЭС ХАМГААЛАХ, АЮУЛГҮЙ БАЙДЛАА ХАНГАХ ЧАДАВХЫГ НЭМЭГДҮҮЛЭХЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ НЬ” ТӨСӨЛ

2023 он



Санхүүжүүлэгч: Шинэ Зеланд Улсын Элчин Сайдын Яамны Сан



Хэрэгжих хугацаа: 2023 оны 1 сараас 2024 оны 1 сар



Төсөлд хамрагдсан байгууллагууд:

- Баянзүрх дүүргийн Ерөнхий боловсролын 79-р сургууль,
- Баянзүрх дүүргийн Насан Туршийн Боловсролын төв,
- Сонгинохайрхан дүүргийн Ерөнхий боловсролын 65-р сургууль,
- Сонгинохайрхан дүүргийн Насан Туршийн Боловсролын төв,
- Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхэдтэй Эцэг Эхийн холбоо,
- Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 1-р сургууль,
- Өвөрхангай аймгийн Насан Туршийн Боловсролын төв,
- Өвөрхангай аймгийн Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхэдтэй Эцэг Эхийн Холбоо



Төслийн зорилго:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бэлгийн хүчирхийллээс өөрийгөө хамгаалах аргад суралцахад нь дэмжлэг үзүүлэх; хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд учирч болзошгүй бэлгийн хүчирхийллийн эрсдэл, үр дагавраас сэргийлэх, тэдгээрийг бууруулахад зохих заавар, дэмжлэг үзүүлэх чиглэлээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагчид, боловсролын байгууллагын ажилтнуудыг чадавхжуулах зорилготой хэрэгжиж байна.



Төслийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл:

Хүний эрхийн тухай мэдлэг ойлголттой болох, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, тэдгээрийн эрсдэлийг таних, урьдчилан сэргийлэх арга, эрүүл мэнд, нөхөн үржихүйн, ялангуяа бэлгийн цогц боловсролтой болох нь чухал тул хүүхдийн үндсэн эрх, хамгаалал, эрхийн зөрчил буюу хүчирхийллийн хэлбэрүүд, шилжилтийн насны онцлог, нөхөн үржихүйн эрүүл мэнд, цахим орчны аюулгүй байдлын тухай мэдээллийг багтаасан, хүүхдүүдэд болон насанд хүрэгчдэд зориулсан хоёр гарын авлагыг төслийн хүрээнд боловсрууллаа.

Мөн эдгээр гарын авлагад тусгасан арга зүйг багш, эцэг эхчүүдэд болон хүүхдүүдэд хүргэх сургагч багшийн сургалтыг 2023 оны 8 сарын 29-ний өдөр Монгол-Японы төвд зохион байгуулж, төсөлд хамрагдаж буй байгууллагуудын төлөөлөл бүхий 17 хүн сургагч багшаар бэлтгэгдэв.

Сургагч багш нар сургалтаас олж авсан арга зүйдээ тулгуурлан өөр өөрийн байгууллагадаа тус сургалтыг багш, эцэг эхчүүд, сурагчдын төлөөлөлд зохион байгуулж байна.



Сургалтад оролцогчид, Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын “Богд” зочид буудлын сургалтын танхим, 2023.09.25.



Сургалтын зөвлөх Р.Балжинням тэгш хамруулах боловсролын манлайлагчийн талаар танилцуулж байна. Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын “Богд” зочид буудлын сургалтын танхим, 2023.09.25.

# ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Улаанбаатар хотын гурван дүүрэг, Өвөрхангай болон Ховд аймгийн зорилтот сургуулиудын бага, дунд ангийн хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

## ТӨСЛИЙН ЗОРИЛТУУД

- 1 Зорилтот сургуулийн 5-р ангийн сурагчдыг дунд ангид дэвшин суралцахад дэмжлэг үзүүлэх;
- 2 Суурь боловсролын түвшинд тэгш хамруулан сургах боловсролын тогтолцоог бий болгох;
- 3 Зорилтот сургуулийн эцэг эхчүүдэд хүүхдийнхээ анги дэвших болон цаашид суралцах үйл явцад туслахад дэмжлэг үзүүлэх;
- 4 Төслийн үр дүнд амжилттай хэрэгжсэн загвар, үйл ажиллагааг сурталчлах, тэгш хамруулан сургах боловсролын төрийн бодлогод тусгах

## ТӨСЛИЙГ САНХҮҮЖҮҮЛЭГЧ

Япон улсын Гадаад Хэргийн Яам

## ТӨСЛИЙН ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА

3 жил (2021 оны 3 сар - 2024 оны 3-р сар)

## ТӨСЛИЙН ҮР ШИМИЙГ ХҮРТЭГСЭД:

**Шууд:** 20,606    **Шууд бус:** 28,650

## ТӨСӨЛД ХАМРАГДАЖ БҮЙ ЕБС-ИУД

Баянзүрх дүүргийн 79, 127, 30-р сургууль,  
Амгалан цогцолбор сургууль  
Чингэлтэй дүүргийн 37, 49, 39, 61-р сургууль  
Сонгинохайрхан дүүргийн 67, 65, 9, 76-р сургууль  
Өвөрхангай аймгийн 2-р сургууль, Уянга сумын 1-р сургууль  
Ховд аймгийн 7, 3-р сургууль



🏠 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Аризона төв, 4-р давхар  
☎ +976-11-329365, +976-11-329371  
📠 +976-11-329361  
✉ Mongolia.secretary@savethechildren.org

🌐 www.savethechildren.mn  
📍 Save the Children in Mongolia  
🌐 Savethechildren.mongolia  
🇺🇸 Save the Children MN  
📍 Save the Children in Mongolia